

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний
тухай хуулийн шинэчилсэн
найруулгын төслийн талаар

Монгол Улсын Үндсэн хуульд заасан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөг баталгаажуулах, сэтгүүл зүйн хараат бус, бие даасан, ил тод байдлыг хангах, хэвлэл мэдээллийн салбарын өөрийн зохицуулалтын байгууллагын эрх зүйн үндсийг тогтоох замаар олон ургальч, хариуцлагатай хэвлэл мэдээллийн салбар хөгжихийг дэмжих үндсэн зорилготойгоор хуулийн төслийг боловсруулсан болно.

1998 онд баталсан Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль нь хэвлэн нийтлэх эрх чөлөөг баталгаажуулж, төрөөс хэвлэл мэдээлэлд агуулгын хяналт тогтоохгүй байх, төр өөрийн эзэмшилд хэвлэл мэдээллийн байгууллага ажиллуулахгүй байх, хэвлэл мэдээллийн байгууллага нь нийтэлж, нэвтрүүлсэн мэдээллийн үнэн зөв байдлыг хариуцах зэрэг хэвлэн нийтлэх эрхийг хангахтай холбоотой үндсэн суурь зохицуулалтыг тусгасан бөгөөд өөрийн түүхэн үүргээ гүйцэтгэсэн хууль юм.

Гэвч мэдээлэл, технологийн салбарын хурдацтай хөгжил, мэдээлэл дамжуулах, нийтлэх, хүлээн авах олон төрлийн суваг, боломж бий болсонтой зэрэгцэн хүн бүрт хэвлэн нийтлэх эрх илүү ойр бөгөөд энэ нь улам өргөн хүрээний ойлголт болж байна. Иймд Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийг цаг үеийн шаардлагад нийцүүлэн боловсруулах, иргэний үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөнөөс сэтгүүл зүйг ялгах, хараат бус, бие даасан сэтгүүл зүйн хөгжлийг дэмжих зохицуулалт бий болгох хэрэгцээ, шаардлага үүсээд байгаа болно. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төслийн шинэчилсэн найруулгыг цаг үе, дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлага, олон улсын хүний эрхийн байгууллагуудаас баримталж буй зарчим, зөвлөмж, улс орнуудын уг салбарт хэрэгжүүлсэн туршлага, өөрийн улсын онцлог зэргийг харгалзан боловсрууллаа.

Хуулийн төслийг боловсруулах ажлыг Хууль зүй, дотоод хэргийн сайдын А/52 дугаар тушаалаар байгуулаглагдсан төрийн болон төрийн бус байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлч, энэ салбарыг судалдаг эрдэмтэн судлаачдаас бүрдсэн Ажлын хэсэг гүйцэтгэсэн болно.

Хэвлэн нийтлэх эрх нь үзэл бодлоо илэрхийлэх эрхийн бүрэлдэхүүн хэсэг, түүнийг илэрхийлэх нэг хэлбэр бөгөөд уг эрхийг хэрэгжүүлэх этгээд нь ихэвчлэн хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлч зэрэг мэргэжлийн, хүчтэй бүлэг олон нийтийн дуу хоолойг илэрхийлэн оролцдог тул хэвлэн нийтлэх эрхтэй холбоотой харилцааг бие даасан хуулиар зохицуулдаг байна. Олон оронд хэвлэлийн эрх чөлөөг үндсэн хуулиар баталгаажуулахын зэрэгцээ бие даасан хуулиар хамгаалсан байдаг бөгөөд улс бүрийн уг эрхийг хамгаалах цар хүрээ, тулгарч буй бэрхшээлүүдийг харилцан адилгүй байдлаар хуульчилсан байдаг ч ерөнхийдөө хэд хэдэн үндсэн чиглэлийг заавал зохицуулсан байна. Үүнд:

1. Агуулгын хяналт (цензур)-аас ангид байх: Энэ хууль нь хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчид төр, эзэн, ивээн тэтгэгч зэрэг аливаа этгээдийн хөндлөнгийн

оролцоо, цензургүйгээр ажиллах боломжийг хуулиараа баталгаажуулдаг зарчим нийтлэг байна.

2.Сэтгүүлчдийн эх сурвалж нууцлах эрхийг хамгаалах: Энэхүү хамгаалалт нь сэтгүүлчдэд чөлөөтэй ажиллах, олон нийтийн эрх ашгийг хөндсөн асуудлыг судлах, шүгэл үлээгч этгээд сэтгүүлчид итгэх боломжийг олгодог чухал үүрэгтэй зохицуулалт юм.

3.Хэвлэл мэдээллийн өмчлөлийн ил тод байдлын зохицуулалт: Энэ нь үзэл бодлын олон талт байдлыг хангах, хэвлэл мэдээллийн олон ургальч үзлийг алдагдуулах монополь үүсэхээс урьдчилан сэргийлэхийн тулд хэвлэл мэдээллийн өмчлөл, төвлөрөлтэй холбоотой асуудлыг зохицуулдаг байна.

4.Өргөн нэвтрүүлгийн стандарт: Өргөн нэвтрүүлгийн зохицуулалттай орнуудын хувьд энэ хуульд үнэн зөв, шударга, хувь хүний эрхийг хүндэтгэх зарчмуудыг баримтлах өргөн нэвтрүүлгийн контентын стандартыг тусгах байна.

5.Хэвлэл мэдээллийн салбарын өөрийн зохицуулалтын байгууллага: хэвлэл мэдээллийн салбар нь хараат бус байж гэмээн олон ургальч байдлаар асуудалд хандах боломжтой тул энэхүү салбарт мөрдөгдөх ёс зүйн дүрэм, стандарт, бусад хэм хэмжээ зэргийг төрийн эсхүл аль институцийн оролцоотойгоор батлах нь өөрөө хэвлэл мэдээллийн байгууллагын хараат бус, бие даасан байдалд сөргөөр нөлөөлөх боломжтой гэж үздэг тул хэвлэл мэдээллийн салбарынхан өөрсдөө, сайн дураараа нэгдэх замаар өөрийн зохицуулалтын байгууллагыг байгуулж, түүнээс баталсан хэм хэмжээг үйл ажиллагаандаа баримтлан ажилладаг туршлага байна. Улс орон бүрт өөрийн зохицуулалтын байгууллага нь харилцан адилгүй эрх, үүрэгтэй байх боловч нийтлэгээр ёс зүйн хэм хэмжээ, стандартыг батлан мөрдүүлэх, ёс зүйн зөрчлийг шийдвэрлэх, хэвлэл мэдээллийн салбарын зүй ёсны хөгжлийг дэмжихэд хэвлэл мэдээллийн байгууллагад туслах чиг үүрэгтэй байна.

Дээрх чиг хандлага, хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг тандан судалсан тайлан, бусад судалгаа, нөхцөл байдлын үнэлгээ зэргийг харгалзан хэвлэл нийтлэх эрхээ хэрэгжүүлэхдээ бусдын нэр төр, нийгмийн ёс суртахуун, үндэсний аюулгүй байдалд хохирол учруулахгүй байх зарчмыг баримтлан Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг дараах байдлаар боловсрууллаа.

Хуулийн төсөл нь 6 бүлэг, 16 зүйлтэй. Нийтлэг үндэслэл бүлэгт хууль хэрэглээг ойлгомжтой болгох зорилгоор хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлч, хамтын хэвлэл мэдээллийн байгууллага, редакц, эх сурвалжаа нууцлах эрх зэрэг үндсэн ойлголтын талаар нэр томъёоны тодорхойлолт тусгав. Түүнчлэн “ташаа мэдээлэл”, “илт худал мэдээлэл” гэх ойлголтыг олон улсын хандлага, уг ойлголтын агуулга, мөн чанар, Монгол Улсын хууль тогтоомжид хэрэглэсэн нэр томъёонд нийцүүлэн тодорхойлов.

Сэтгүүлч гэдэгт зөвхөн мэргэжлийн сургууль төгссөн, хэвлэл мэдээллийн байгууллагад харьяалагдан ажилладаг этгээдээс гадна олон нийтийн эрх ашиг сонирхлын төлөө мэдээ, мэдээлэл бэлтгэн, бие даан цахим болон бусад орчинд сэтгүүлзүйн үйл ажиллагааны гүйцэтгэж этгээдийг /чөлөөт сэтгүүлч/ хамруулахаар боловсрууллаа. Ингэхдээ чөлөөт сэтгүүлчийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл ашиглан нийтэлж, нэвтрүүлсэн бүтээлтэй холбоотой харилцаа нь энэ хуулийн зохицуулалтад хамаарахаар тусгасан болно.

Хоёрдугаар бүлэгт хэвлэл мэдээллийн хараат бус байдлын баталгаатай холбоотой зохицуулалтууд буюу төрөөс хэвлэн нийтэлсний төлөө аливаа хэлбэрээр дарамтлах, хэвлэн нийтлэх бүтээлд агуулгын хяналт тогтоох, чөлөөт байдлыг зүй бусаар хязгаарласан хууль, захиргааны хэм хэмжээний акт батлахыг тус тус хориглож, төрийн зүгээс хэвлэл мэдээллийн үйлчилгээ авах бол ил тод, нээлттэй зарлах, төр өөрийн дэргэд хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байхгүй талаар зохицуулалт тусгалаа. Түүнчлэн хэвлэл мэдээллийн байгууллага нь олон нийтэд түгээх мэдээллийн агуулга, бодлогыг тодорхойлох, бүтээх, редакторлох үйл ажиллагааг зохион байгуулах редакцтай байх, редакц нь хараат бусаар мэргэжлийн үйл ажиллагаагаа явуулах боломжийг бүрдүүлэхтэй холбоотой зохицуулалт тусгалаа.

Гуравдугаар бүлэгт хэвлэл мэдээллийн байгууллагын ил тод байдлыг хангах зорилгоор хэвлэл мэдээллийн байгууллагын төрөл, зорилго, хэлбэрийг тогтоож, ашгийн төлөө үйл ажиллагаа явуулж байгаа бол хэвлэл мэдээллийн байгууллага нь хуулийн этгээдийн хувьд компанийн хэлбэрээр зохион байгуулагдсан байхаар зохицуулав. Хэвлэл мэдээллийн байгууллага нь эзэмшигч, хувьцаа эзэмшигч, эцсийн өмчлөгчөө олон нийтэд ил тод байлгах, өөрийн нийтэлж нэвтрүүлсэн мэдээ, мэдээллийн үнэн зөвийг бүрэн хариуцаж алдаатай мэдээлэл нийтэлсэн залруулга хийдэг байх зэрэг үүргийг тусгав.

Хэвлэл мэдээллийн салбарт хэт төвлөрөл үүсэх нь олон ургальч үзлийг хязгаарлах, хэвлэл мэдээллийн хэрэгслийг буруу зорилгоор ашиглах эрсдэлтэй тул хэт төвлөрөл үүсэхээс сэргийлэх, шударга өрсөлдөх талаар тусгаж, энэ талаарх нарийвчилсан харилцааг холбогдох хуулиар зохицуулахаар заалаа.

Олон ургальч хэвлэл мэдээлэл оршин байх орчин бүрдүүлэхийн тулд эзэмшлийн ил тод байдлыг хангах, хэт төвлөрөл үүсгэхгүй байх, хэвлэл мэдээллийн олон янз байдлыг дэмжих гэсэн гурван үндсэн нөхцөлийг хангах нь чухал байдаг. Хэвлэл мэдээллийн олон янз байдал гэдэгт арилжааны, олон нийтийн, хамтын (community media) хэвлэл мэдээллийн байгууллага гэсэн гурван үндсэн төрлийг олон улсад нийтлэгээр хүлээн зөвшөөрсөн байдаг бөгөөд манай улсад мөн эдгээр төрлийн хэвлэл мэдээллийн байгууллага ажиллаж байгаа болно.

Иймд хуулийн төсөлд хэвлэл мэдээллийн дээрх хэлбэрүүдийг тусгаж, олон нийтийн хэвлэл мэдээллийн байгууллага нь Олон нийтийн радио, телевизийн тухай хуулиар зохицуулагдаж байгаа тул үүнийг тодруулан, олон нийтийн болон хамтын хэвлэл мэдээллийн байгууллагаас бусад бүх хэвлэл мэдээллийн байгууллага нь арилжааны төрлөөр, компанийн хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулахаар зохицуулав.

Ингэснээр хуулийн төслийн дагуу хэвлэл мэдээллийн бүх байгууллага нь редакцтайгаар, хуулийн этгээдийн хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулах шаардлагатай болж байгаа болно. Энэ нь хэвлэл мэдээллийн байгууллагыг хариуцлагатай, бодит, тэнцвэртэй мэдээлэл түгээдэг байдлаараа ялгарахад дэмжлэг үзүүлнэ хэмээн үзэж байна.

Дөрөвдүгээр бүлэгт хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчийн мэдээллийн эх сурвалжаа нууцлах эрхийг баталгаажуулж өгөв. Эх сурвалжаа хамгаалах, нууцлах эрх нь Монгол Улсын хувьд одоогийн хууль эрх зүйн хувьд /олон нийтийн радио телевизийнхээс бусад/¹ сэтгүүлчдэд олгогдоогүй тул энэ эрх ихэнх сэтгүүлчдийн хувьд баталгаажаагүй байна.

¹ Олон нийтийн радио, телевизийн тухай хууль, 2005 он.

Үүнээс шалтгаалаад шүүхийн шатанд болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үеэр сэтгүүлчдийг эх сурвалжаа илчлэхийг албадан шаардах, ажил үүргээ гүйцэтгэхэд нь саад дарамт болох боломж байсаар байна. Хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчид мэдээллийн эх сурвалжаа нууцлах эрхийг хуулиар олгохгүй тохиолдолд олон нийтийн эрх ашигтай холбоотой чухал мэдээллийн эх сурвалжууд нь өөрийн аюулгүй байдал, ашиг сонирхолд санаа зовж сэтгүүлчид итгэл хүлээлгэж, мэдээлэл өгөхгүй тул сэтгүүлчид чухал мэдээллүүдийг олон нийтэд хэвлэн мэдээлэх боломж нь хязгаарлагдаж байгааг арилгах зорилгоор эх сурвалжаа нууцлах эрхийг баталгаажуулав. Ингэхдээ тухайн мэдээллийн нууц эх сурвалжийг өөр арга замаар олж мэдэх боломжгүй бөгөөд хүний амь нас, эрүүл мэндэд бодит хохирол учруулахуйц гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үндэслэлтэй гэж үзвэл сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллага эх сурвалжаа задруулах эсэхээ өөрөө дэнслэн шийдвэрлэдэг байхаар зохицуулав.

Тавдугаар бүлэгт хэвлэл мэдээллийн салбарын өөрийн зохицуулалтын байгууллагын талаар зохицуулалт тусгалаа. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөг төрөөс хараат бус байдлыг хангахын тулд энэ салбар дахь төрийн оролцоог аль болох хамгийн бага хэмжээнд байлгахыг олон улсад эрмэлздэг ба энэ зорилгоор хэвлэл мэдээллийн салбарын өөрийн зохицуулалтын байгууллага байх эрх зүйн орчинг бий болгож салбарынхан өөрсдөө уг байгууллагаа байгуулдаг туршлага байна. Манай улсад мөн практик дээр Хэвлэл мэдээллийн зөвлөл ажиллаж байгаа болно.

Хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалт гэдэг нь хэвлэл мэдээллийн ёс зүйн хүрээнд сэтгүүл зүйн бүтээлийн чанарыг хэлэлцэх замаар хэвлэл мэдээллээр түгээсэн мэдээллийн улмаас хохирсон этгээдийн эрхийг хамгаалах тогтолцоо бөгөөд энэ нь төр, улс төр, бизнес, бусад хүчин зүйлсээс хараат бус, бие даасан, салбар нь өөрсдөө бий болгож, хүлээн зөвшөөрч, цаашид үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх сайн дурын бүтэц юм. Иймд энэхүү бүтцийг хүлээн зөвшөөрч хуулийн төсөлд тусгаж байгаа болно.

Төсөлд туссанаар хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын байгууллага нь бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаагаа бие даан шийдвэрлэх, салбарын мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг баталж, уг ёс зүйн хэм хэмжээг редакц, сэтгүүлчийн нийтлэл, нэвтрүүлэг зөрчсөн талаарх хүн, хуулийн этгээдээс гаргасан гомдлыг шийдвэрлэх чиг үүрэгтэй байхаар эрх зүйн үндсийг тогтоолоо.

Түүнчлэн сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагын мэргэжлийн алдаа гаргасан талаар хүн, хуулийн этгээд редакцид болон өөрийн зохицуулалтын байгууллагад гомдол гаргах нь сайн дурын шинжтэй бөгөөд энэ нь уг этгээдийн шүүхэд гомдол гаргах эрхийг хязгаарлахгүй юм.

Өөрийн зохицуулалтын байгууллага хөгжих нь сэтгүүл зүйг ёс зүйн хэм хэмжээгээ баримталдаг, мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлдэг болоход дэмжлэг үзүүлдэг сайн туршлага юм.

Төслийн зургадугаар бүлгээр хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагын хэм хэмжээ болон хууль хүчин төгөлдөр болохтой холбоотой зохицуулалт тусгалаа.

34.2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийтийн ашиг сонирхол хөндөгдсөн гэж шүүх үзэж ил болгосноос бусад тохиолдолд олон нийтийн радио, телевизийн ажилтан мэдээллийн эрх сурвалжийг нууцлах эрхтэй.

Дагалдуулан боловсруулсан хууль тогтоомжийн төслийн танилцуулга:

1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.10 дахь хэсэгт “Засгийн газрын бодлого, шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт болон цаг үеийн шинжтэй мэдээллийг яаралтай олон нийтэд хүргэх, мэдээлэхэд шаардлагатай хэвлэл мэдээллийн үйлчилгээ, Үндэсний их баяр наадмын тухай хуульд заасан улсын баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбоотой үндэсний үнэт зүйл, соёлын өвийг таниулсан соёл, урлагийн арга хэмжээ, тоглолт, урлагийн бүтээлийг худалдан авахад нээлттэй тендер шалгаруулалтын аргыг хэрэглэхгүй байж болно.” гэж заасан байдаг. Энэ нь төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээдүүд нь хэвлэл мэдээллийн үйлчилгээг ямар нэг нээлттэй шалгуургүйгээр өөрийн сонгосон хэвлэл мэдээллийн байгууллагаас шууд авах, хэвлэл мэдээллийн байгууллагын хооронд шударга өрсөлдөөнийг бий болгохгүй байх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2023 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр 2023-2030 он”-ын зорилт 3.4.3-т “Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн шилэн дансны мэдээлэлд хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчтэй байгуулсан гэрээ, төлсөн төлбөрийг тусгайлан мэдээлэх журам, стандартыг баталж, мөрдүүлнэ.” гэж заасан болон Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалд нийцүүлэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.10 дахь хэсэгт заасан “Засгийн газрын бодлого, шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт”-ийн талаар сурталчилуулах тохиолдолд нээлттэй тендер шалгаруулалт хэрэглэхгүй байж болохоор байгааг өөрчилж, хасахаар хуулийн төсөл боловсруулсан болно.

2.Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн талаар:

Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль зөрчихтэй холбоотой хэвлэл мэдээллийн бие даасан байдалд нөлөөлсөн, хараат бус байдлыг алдагдуулсан, шүүхийн шийдвэр гараагүй байхад сэтгүүлчийн эх сурвалж нууцлах эрхийг хөндсөн зэрэг хоёр төрлийн үйлдлийг зөрчилд тооцон Зөрчлийн тухай хуульд нэмэлтээр тусгаж байгаа болно.

Түүнчлэн Зөрчлийн тухай хуулийн 10.1 дүгээр зүйлд Зар сурталчилгааны тухай хууль зөрчих зөрчлийг зааж өгсөн бөгөөд мөн зүйлийн 1 дэх хэсгийн 1.3 дахь заалтад “хуулиар түгээхээр тусгайлан заасан сэрэмжлүүлгийг тухайн хэвлэл мэдээллийн хэрэгслийн нэвтрүүлгийн хөтөлбөрийг харгалзалгүйгээр холбогдох шийдвэрт заасан давтамжаар үнэ төлбөргүйгээр түгээгээгүй бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” гэсэн нь Зар сурталчилгааны тухай хуультай холбоогүй бөгөөд Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2 дахь хэсэгт “Хэвлэл мэдээллийн байгууллага гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүнийг таслан зогсоохтой холбогдсон хойшлуулшгүй мэдээллийг эрх бүхий байгууллагын хүсэлтээр үнэ төлбөргүйгээр яаралтай нийтэлж, нэвтрүүлнэ.” гэж заасантай давхардсан бөгөөд Зөрчлийн тухай хуулийн 5.9 дүгээр зүйлд Гэмт хэрэг,

зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль зөрчихөд ногдуулах шийтгэлийг томъёолсон тул хуулийн давхардлыг арилгах зорилгоор Зөрчлийн тухай хуулийн 10.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.3 дахь заалтыг хүчингүй болгохоор хуулийн төсөл боловсрууллаа.

3.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Зөрчлийн тухай хуульд Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль зөрчихтэй холбоотой зөрчил нэмэгдэж байгаатай холбоотойгоор уг зөрчлийг шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтны харьяаллыг тогтоох зорилгоор Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн 6.8 дахь заалт буюу цагдаагийн байгууллагын эрх бүхий албан хаагч мөн зөрчлийг шалган шийдвэрлэхээр нэмэлт оруулж байгаа болно.

4.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгагдсан зарчмын шинжтэй нэг асуудал нь хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчийн эх сурвалж нууцлах эрхийг баталгаажуулж өгч буй явдал юм. Эх сурвалж нууцлах эрхийг зөвхөн Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний хуулиар баталгаажуулахаас гадна Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд мөн эх сурвалжийн талаар мэдүүлэг өгөхгүй байх эрхтэйг зааж өгөх шаардлагатай болно.

Ийнхүү нэмэлтийг оруулахдаа бусад улс орны жишгийг харгалзан судалсны үндсэн дээр манай улстай эрх зүйн бүлийн хувьд нэг тогтолцоонд хамаарах ХБНГУ-ын эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд мөрдөгддөг сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагын эх сурвалж нууцлах эрхийг баталгаажуулсан зохицуулалт болон өөрийн орны онцлогыг харгалзан холбогдох нэмэлтийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд тусгахаар төсөл боловсрууллаа.

Ингэхдээ хэвлэл мэдээллийн байгууллагын сэтгүүл зүйн үйл ажиллагааны хүрээнд мэдээ, мэдээлэл бэлтгэх, түгээх ажилд мэргэжлийн үүргээр оролцсон этгээд нь уг үүргийнхээ хүрээнд хүлээн авсан мэдээллийн эх сурвалжийн талаар мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхтэй бөгөөд энэ эрх нь зөвхөн редакцаар дамжсан сэтгүүл зүйн үйл ажиллагаанд хамаарах мэдээ, баримтын агуулгад хамаарахаар тусгалаа.

Түүнчлэн эх сурвалжаа нууцлах эрх хязгааргүй эрх биш тул сэтгүүлчээс зарим төрлийн хүнд гэмт хэргийн бодит байдлыг тогтоох, гэмт хэргийг илрүүлэх, түүнийг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоох зорилгоор түүний боловсруулсан мэдээллийн агуулга болон холбогдох эх сурвалжийн талаар мэдүүлэг авч болохоор тусгалаа.

5.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэгт иргэн нь “бусдын нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хохироохгүй байх, өөрийн үзэл бодлыг илэрхийлэхдээ бусдын нэр төр, алдар хүндэд хүндэтгэлтэй хандах, гэмт хэрэг, зөрчилд бусдыг өдөөн хатгахгүй, олон нийтийн аюулгүй байдал, нийтийн хэв журмыг гажуудуулах үйлдэл гаргахгүй байх;” гэж заасан

бөгөөд Зөрчлийн тухай хуулийн 5.9 дүгээр зүйлд тус хуулийг зөрчсөн талаарх зөрчлийг томъёолохдоо “1.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан үүргээ биелүүлээгүй бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” гэсэн нь иргэдийн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг үндэслэлгүй, хэтрүүлэн хязгаарласан, бусад хуулиар зохицуулагдаж байгаа харилцааг давхардуулж, Зөрчлийн тухай хуулиар хариуцлага оногдуулж байх тул Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсгийн “бусдын нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хохироохгүй байх, өөрийн үзэл бодлыг илэрхийлэхдээ бусдын нэр төр, алдар хүндэд хүндэтгэлтэй хандах” гэсэн хэсгийг хүчингүй болгохоор хуулийн төсөл боловсрууллаа.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 32 дугаар зүйлд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хэвлэл мэдээллийн байгууллагын үүргийг тогтоож өгсөн байдаг. Гэтэл энэ хэсэгт “хэвлэл мэдээллийн хэрэгслийн мэдээлэл, нийтлэлийн агуулга, хөтөлбөртөө гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг, зөрчилд өртөж, хохирох, болзошгүй эрсдэлээс өөрийгөө болон бусдыг хамгаалах, өөрийн эрх, ашиг сонирхлыг хууль ёсны аргаар хамгаалах арга замыг тодорхой тусгаж хэрэгжүүлнэ.”, “дээрх агуулга бүхий нийтлэл, мэдээллийг тухайн хэвлэл мэдээллийн хэрэгслээр нэвтрүүлж, нийтэлж байгаа нийт мэдээлэлд эзлэх хувь, заавал нэвтрүүлбэл зохих нийтлэл, мэдээллийн доод хэмжээг хууль зүйн болон харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.” зэрэг зохицуулалт тусгасан нь Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай² хуулийн 3 дугаар зүйлд заасан “Төрөөс олон нийтийн мэдээллийн агуулгад хяналт /цензур/ тогтоохгүй.”, Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлал, зарчимтай зөрчилдөж байгаа бөгөөд хэвлэл мэдээллийн байгууллагын агуулгыг бүтэн хянаж буй хэлбэр байх тул Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 32 дугаар зүйлд заасан зарим заалтыг хүчингүй болгохоор хуулийн төсөлд тусгасан болно.

Нийгмийн хариуцлагын хүрээнд хэвлэл мэдээллийн байгууллага нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүнийг таслан зогсоохтой холбогдсон хойшлуулшгүй болон бага насны хүүхэд сураггүй алга болсон талаарх мэдээллийг эрх бүхий байгууллагын хүсэлтээр үнэ төлбөргүй дамжуулж байх нь зүй ёсны хэрэг тул эдгээрээс бусад хэвлэл мэдээллийн байгууллагын нийтэлж, нэвтрүүлэх мэдээллийн агуулгыг хянах утга бүхий 2 хэсэг, шаардлагагүй дүрэм, журам батлах эрх олгосон агуулга бүхий 3 хэсгийг тус тус хүчингүй болгохоор хуулийн төсөл боловсруулсан болно.

6.Хууль хүчингүй болгох хуулийн төслийн талаар:

Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсантай холбоотойгоор 1998 онд батлагдсан Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийг цаашид хэрэглэхгүй болж байгаа тул уг хуулийг хүчингүй болгох хуулийн төслийг боловсрууллаа.

ХУУЛЬ САНААЧЛАГЧ

² 1998 онд батлагдсан Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн 3 дугаар зүйл.